

УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр

№	Баталсан газар	Актын дугаар	Акт батлагдсан огноо	Актын нэр	Актын зүйл, заалт
1	Сонгуулийн Ерөнхий хороо, Харилцаа Холбооны Зохицуулах хорооны хамтарсан тогтоол	29/17	2016.04.26	Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам	<p>Гурав. Сонгуулийн сурталчилгааг телевиз, радиогоор нэвтрүүлэх</p> <p>3.1.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 1.3-т заасан өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн жагсаалтыг энэ журмын хавсралтын дагуу гаргаж, санал авах өдрөөс 45 хоногоос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.</p> <p>3.3.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 3.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо болон аймгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулан нийтэд ил тод мэдээлнэ.</p>
2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	38	2009.10.22	Даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй үзүүлэх эрхээр урамшуулах журам батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй үзүүлэх эрхээр урамшуулах журам</p> <p>7.1 Энэ журмын хэрэгжилтэнд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах байгууллага болон үйлдвэрчний эвлэлийн холбоодоос хяналт хийж болно.</p>

№	Баталсан газар	Актын дугаар	Акт батлагдсан огноо	Актын нэр	Актын зүйл, заалт
1	Татварын ерөнхий газрын дарга	225	2009.06.15	Журам батлах тухай /Зөрчил бүхий татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх журам/	Гурав. Зөрчил бүхий татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх 3.4.1.Энэхүү журмын 2.2, 2.3-т заасан татвар төлөгчийг нийтэд мэдээлэхээс өмнө холбогдох татвар төлөгчид түүнийг нийтэд мэдээлэх гэж байгаа талаараа урьдчилан анхааруулна.
2	Газры харилцаа, геодизи, зураг зүйн газрын дарга	83	2008.04.14	Журам батлах тухай /Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам/	3.5. Газрын алба, сумын Газрын даамал тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг болон түүний дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж нийтэд хүртээмжтэй газарт байрлуулсан байна. 10.19. Газрын албаны даргын тушаалаар хүчингүй болсон эрхийн гэрчилгээний талаархи мэдээллийг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.
3	Оюуны өмчийн газрын дарга	59	2014.04.08	“Барааны тэмдэг нийтэд түгээмэл болсонд тооцох журам”-ыг батлах тухай /Барааны тэмдэг нийтэд түгээмэл болсонд тооцох журам /Хавсралт 1//	4.4. Төрийн захиргааны байгууллага тухайн барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцсон талаар Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ. 4.7. Тухайн барааны тэмдгийн нийтэд түгээмэл болсонд олгосон эрхийн хамгаалалт дуусгавар болсон тухай Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ
4	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга	38	2011.01.17	Журам батлах тухай /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам/	10.6.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хаасан тохиолдолд тухайн бүртгэлийн үндсэн дээр олгогдсон байсан эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож, хаагдсан хувийн хэрэгт хавсарган хадгална. Хэрэв гэрчилгээг хураан авах боломжгүй бол Улсын ерөнхий бүртгэгчийн тушаалаар хүчингүй болгож, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр мэдээлнэ.

№	Баталсан газар	Актын дугаар	Акт батлагдсан огноо	Актын нэр	Актын зүйл, заалт
1	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Тогтоол	131	2011.09.07	Журам батлах тухай	<p>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам (хавсралт 1)</p> <p>Гурав. Иргэдийн хүлээх үүрэг</p> <p>3.1.5.Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд Нийслэл, дүүрэг, хорооноос зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох;</p> <p>3.1.7.Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаар эрх бүхий этгээдэд үнэн зөв мэдээлэх;</p> <p>3.1.8.Агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.</p>
2	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Тогтоол	9/10	2017.04.27	Журам шинэчлэн батлах тухай	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам (хавсралт 1)</p> <p>Дөрөв. Гадна зар сурталчилгааг байрлуулах зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах</p> <p>4.2.4.орон сууцны зориулалттай барилгын цонхгүй цул хана, дээвэрт сурталчилгааны байгууламж байрлуулах бол тухайн сурталчилгаа байрлуулах хэсэгт хамааралтай орон сууц өмчлөгчдийн дийлэнх олонхи зөвшөөрсөн нөхцөлд Сууц өмчлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн байх.</p>